



**Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг
дахь салбар зөвлөл**



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023.01.09.

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн албаны ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс өгсөн зөвлөмж, үүрэг чиглэлийн дагуу Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үйл ажиллагааг тогтмолжуулан тодорхой ахиц дэвшил, үр дүнд хүрч ажиллаж байна.

Тус салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 138 дугаар тогтоол батлагдсан доорх бүтэц бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж нутгийн захиргаа болон салбарын төрийн байгууллагуудад төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэмд заасан төрийн албаны хүний нөөцийн удирдлагатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

**Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь
салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:**

Даргын үүргийг гүйцэтгэгч:	Ш.Гомбодорж	(аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга)
Гишүүд:	Т.Байгалмаа	(Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор)
	Ц.Эрдэнэцогт	(Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга)
	А.Лхагвадорж	(Архангай аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)
	Р.Гандиймаа	(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)
	Б.Адъяа	(Аймгийн Статистикийн хэлтсийн дарга)
	О.Жавзансүрэн	(Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын дарга)
	Б.Гэрэлчимэг	(Төрийн албаны ахмад ажилтны төлөөлөл)
Нарийн бичгийн дарга	Ж.Эрдэнэтуяа	(аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн Бодлогын баримт бичиг, агентлаг хариуцсан мэргэжилтэн)



Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл



1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл нь аймгийн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан зорилт, төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 бүлгийн хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж баталсан.

2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутам тооцож Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам, аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хэрэгжилтийн явцыг тооцож ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэн биелэлтийг заалт тус бүрээр нь гарган үнэлэлт дүгнэлт өгч холбогдох арга хэмжээг авч ажилласан.

2022 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 92.5 хувьтай хэрэгжсэн. (Салбар зөвлөлийн 2022 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн тайланг хавсаргав)

3. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

2022 онд салбар зөвлөлийн хуралдааныг 8 удаа зохион байгуулж 15 асуудлыг хэлэлцэн 21 тогтоол гаргасан.

2022 онд Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлөөс 21 тогтоол, 97 албан бичиг боловсруулан гаргаж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн тогтоолын хуулбар, лавлагаагаар 15 иргэнд үйлчилсэн.

Салбар зөвлөлөөс гарах шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хангах зорилгоор боловсруулсан бичиг баримтын төслийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулж зохих шийдвэрийг гарган ажиллалаа.

4. Орон нутгийн хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Орон нутгийн захиргааны байгууллага болон салбарын хэмжээнд төрийн албаны тухай хууль тогтоомж, журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх, төрийн албаны шинэчлэл, боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлж үйл ажиллагааг сайжруулах



Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл



зорилгоор тодорхой ажлыг зохион байгуулах, зохицуулах чиглэлээр мэргэшил арга зүйн зөвлөгөө, туслалцаа байнга үзүүлэн ажилласан.

5. Орон нутгийн хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Орон нутгийн хэмжээнд хууль, журмыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудад төрийн албаны шинэчлэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, түүний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж гаргаж ажиллан үр дүнг тооцож ажиллаж байна. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд аймгийн Засаг даргатай хийсэн үр дүнгийн гэрээнд төрийн албаны стандартын хэрэгжилтийг тухайн байгууллага дээрээ хангаж ажиллах талаар тусгасан эсэх болон гэрээний биелэлтэд нь хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тооцон ажиллалаа.

6. Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

2022 онд Удирдлагын Академийн Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад байгууллагын санхүүжилтээр 1, улсын төсвийн санхүүжилтээр 1, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад байгууллагын санхүүжилтээр 22, улсын төсвийн санхүүжилтээр 6, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 7, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 12, нийт 49 албан хаагч хамрагдаж төгссөн.

7. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн

Агентлаг, сумын Засаг даргын тамгын газар, төсөвт байгууллагууд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг байгууллагын онцлог, нөөц бололцоонд тулгуурлан боловсруулан хэрэгжүүлж ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын ажилтнууддаа хоолны мөнгийг сар бүр, түлээ, нүүрсний хөнгөлөлтийг жилд нэг удаа олгож, холбогдох хууль тогтоомж, журамд заасан тусламж, дэмжлэгийг үзүүлэх арга хэмжээг аван ажилласан.

Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлыг Салбар зөвлөл



**Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг
дахь салбар зөвлөл**



хянаж, эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэн аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/192 дугаар захирамжаар 19 албан хаагчид зэрэг дэв шинээр, 96 албан хаагчид зэрэг дэв ахиулан, нийт 115 албан хаагчид зэрэг дэв олгож, захирамжийг агентлаг, сумдад хүргүүлсэн.

№	Зэрэг дэв	Олгосон албан хаагчийн тоо
Ахлах түшмэл	Ахлах түшмэлийн тэргүүн зэрэг	2
	Ахлах түшмэлийн дэд зэрэг	3
	Ахлах түшмэлийн гутгаар зэрэг	3
	Ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг	2
Дэс түшмэл	Дэс түшмэлийн тэргүүн зэрэг	15
	Дэс түшмэлийн дэд зэрэг	26
	Дэс түшмэлийн гутгаар зэрэг	27
	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг	10
Туслах түшмэл	Туслах түшмэлийн тэргүүн зэрэг	4
	Туслах түшмэлийн дэд зэрэг	5
	Туслах түшмэлийн гутгаар зэрэг	11
	Туслах түшмэлийн дөтгөөр зэрэг	7
	Нийт дүн	115

8. Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Байгууллага, сумдаас ирүүлсэн захиалгын дагуу төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам” болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2022 онд төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх 250 албан тушаалын сул орон тоон дээр 8 сонгон шалгаруулалт зохион байгуулж 95 албан тушаалын сул орон тоо буюу 38.0 хувь, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын 15 албан тушаалын сул орон тоон дээр 2 сонгон шалгаруулалт зохион байгуулж 7 албан тушаалын сул орон тоо буюу 46.6 хувийг тус тус нөхсөн байна.

9. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний ерөнхий шалгалт, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 02/559, 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 02/1471, 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 02/1915 албан бичгүүдээр ирүүлсэн чиглэл болон Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу 2022 онд Төрийн албаны ерөнхий шалгалтыг Архангай аймагт 2 удаа зохион байгуулсан.



Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл



2022 оны 04 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан Төрийн албаны ерөнхий шалгалтад оролцохоор нийт 232 иргэн бүртгүүлснээс 201 иргэн шалгалтад оролцож, нийт шалгалтад оролцсон иргэдийн 35.8 хувь буюу 72 иргэн, 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны ерөнхий шалгалтад оролцохоор нийт 157 иргэн бүртгүүлснээс 131 иргэн шалгалтад оролцож, нийт шалгалтад оролцсон иргэдийн 35.1 хувь буюу 46 иргэн, 2022 онд нийтдээ 118 иргэн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн. Шалгалт зохион байгуулах үед иргэдээс ямар нэгэн санал гомдол ирээгүй.

10. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал

Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд аймгийн Засаг дарга 2022 онд аймгийн Засаг даргын тамгын газрын дарга болон агентлагийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний үүргийн биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гэрээний биелэлтийг эрчимжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” /Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/-ын хүрээнд боловсруулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/143 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” /аймгийн Засаг даргын 2022 оны А/394 дүгээр захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулсан/-ын дагуу сум, агентлагийн 2022 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.

11. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч ажилласан байдал, үр дүн

Төрийн байгууллагуудын ёс зүйн хороодыг арга зүйн удирдлагаар хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол ирээгүй байна.



Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл



12. Өргөдөл, гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлсэн байдал.

2022 онд Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах тухай 6, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамруулах тухай 2, тусгай шалгалттай холбоотой 10, албан тушаалд томилохгүй байгаа тухай 2, Төрийн албаны зөвлөлд шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн 2, бусад 3, нийт 25 өргөдөл гомдол ирснийг журмын дагуу шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. 2022 оны өргөдөл, гомдол, ёс зүйн зөрчлийн мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

13. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс санаачлан зохион байгуулж байгаа үйл ажиллагаа мэдээ мэдээллийг Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын www.arkhangai.gov.mn албан ёсны цахим хуудас, "Архангай аймгийн ЗДТГ" Facebook хуудас, болон аймаг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж байна.

Мөн Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн "Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл" гэсэн албан ёсны facebook Page хуудас ажиллуулан, салбар зөвлөлөөс зохион байгуулж буй ажил, зар мэдээг тухай бүр оруулан олон нийтэд мэдээлж байна.

14. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээ ирүүлсэн байдал

Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын төрийн албан хаагчийн 2022 оны бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг нэгтгэн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн программд оруулан, дүн мэдээг Төрийн албаны зөвлөлд хүлээлгэн өгч мэдээ тайланг үнэн зөв хугацаанд нь гаргаж ирүүлэх талаар байгууллага, сумдад арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажилласан.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ ирүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн албан бичгийн дагуу аймгийн салбар агентлаг, сумын Засаг даргын Тамгын газарт мэдээлэл өгч, мөн утсаар холбогдон заавар зөвлөмж өгөн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

15. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс санаачлан аймаг орон нутагтаа ажил мэргэжлээрээ тэргүүлж хамт олноо манлайлан ажиллаж буй ажилтан албан хаагчдыг



**Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг
дахь салбар зөвлөл**



шагнаж урамшуулах зорилгоор аймгийн Засаг даргын шагналд тэргүүний ажилтан гэсэн тэмдэг, үнэмлэхийг шинээр нэмэлтээр оруулан ажилтан албан хаагчдыг шагнаж урамшуулж байна.

16. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн үнэлгээ

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар 2022 онд ямар нэгэн санал гомдол ирээгүй байна.

ХЯНАСАН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ГОМБОДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.ЭРДЭНЭТУЯА